

2025 он 04 сар 09 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэлд зөвшөөрөл олгох тухай

Говь ХК-ийн 2025 оны 1-р улирлын сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлийг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**


1. Говь ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны өдрийн №07 тоот тогтоолоор 2025 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон төсвийг баталсныг дурдсугай.
2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны 2025 оны 04-р сарын 07-ны ээлжит хурлаар дээрх батлагдсан тогтоолын хэрэгжилттэй танилцан хяналт тавьсан бөгөөд дараах төсөвт тусгагдаагүй бараа, ажил үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр хийгдсэн болохыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсугай. Үүнд:

№	Компанийн нэр	Бараа, үйлчилгээ	Үнийн дүн /төгрөг/
1	Улаанбаатар Принт ХХК	Угаалгын заавар хэвлэх үйлчилгээ	9,300,000
2	Улаанбаатар Принт ХХК	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал хэвлэх үйлчилгээ	2,500,000
	Нийт		11,800,000

3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:






Д.ГЭРЭЛМАА



А.ЖАРГАЛМАА



Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ